БАТЛАВ

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ЭРДЭНЭСУВД

2023 оны ... сарын ... ны өдөр

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилго, зөвлөмж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлийн шалгуур үзүүлэлт | Хугацаа | Хэрэгжүүлэх нэгж |
|---|---|---|---|---|
| ***1. 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх*** | | | | |
| 3.Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллах; | 5.4. "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан Засгийн газрын тогтоол, "5Ш" хөтөлбөр, "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг албан хаагчид хүргэн сурталчлах, Засгийн газар, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллах; | Арга хэмжээг хэрэгжүүлж, тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг |
| ***1.Авлигын эсрэг үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх*** | | | | |
| *Зөвлөмж 2.2.* Төрийн албаны их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа их өгөгдөлд суурилсан төрийн албан хаагчийн томилгоог хийх, энэхүү системийг төрийн байгууллагуудын цахим системтэй интеграцжуулахад холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах; | 5.5. Төрийн албаны зөвлөлийн их өгөгдлийн санд татварын албаны хүний нөөцийн бүртгэлийг бүрэн оруулах, их өгөгдлийн санд суурилсан албан хаагчийн томилгоог хийх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах; | Их өгөгдлийн санд мэдээллийг бүрэн оруулсан байх; | Жилд | Хүний нөөцийн мэргэжилтэн |
| *Зөвлөмж 2.4.* Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавигдсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх, томилсон этгээдэд хариуцлага тооцох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд онцгой анхаарах; | 5.6. Албан тушаалын шаардлагыг хангаагүй албан хаагчийг томилохгүй байх, албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон албан тушаалд тусгай шалгалт зарлан томилох; | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байх; | Эхний хагас жилд, жилд | Захиргаа, хуулийн тасаг, Хүний нөөцийн мэргэжилтэн |
| *Зөвлөмж 2.6.* Төрийн худалдан авалт, хангамж нийлүүлэлт, хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр болон эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор авлига, залилангийн гэмт хэрэг гарахад нөлөөлөхүйц хүчин зүйлсийг арилгах, аудит хийхдээ хөндлөнгийн болон дотоод хяналтын зохистой горимыг сонгон хэрэглэх; | 5.8. Хөндлөнгийн болон дотоод хяналтын зохистой горимыг ашиглан худалдан авалтын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг залруулах арга хэмжээг авсан байх; | Худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт тавьсан байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| *Зөвлөмж 2.7.* Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжээс эрхэлж байгаа аливаа үйлчилгээ, үйл ажиллагаанд хуульд заагаагүй зөвшөөрөл олгодог явдлыг таслан зогсоох, төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тогтолцоог халах; | 5.9. Төрийн байгууллагуудтай татвар төлөгчийн мэдээллийг солилцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Мэдээллийг зохих журмын дагуу солилцсон байх; | Жилд | Бүх тасаг |
| *Зөвлөмж 2.10.* Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн иж бүрэн байдлын түвшинг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох, кодлох, шилэн дансны нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх, аудитын явцад олон нийтийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бүрдүүлэх; | 5.11. Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мэдээллийг шилэн дансанд тухай бүр байршуулах; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай, шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг, нягтлан бодогч |
| | **2.Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр** | | | |
| Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | Баримтжуулсан байх;<br>Үр дүнг тооцож, тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо);<br>хамруулсан байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг, хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч |
| | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа гэх мэт соён гэгээрүүлэх арга хэмжээнд оролцсон байх. зохион байгуулсан байх;<br>Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх; | | Захиргаа, хуулийн тасаг, хуулийн зөвлөх |
| | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>Тайлант сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх; | | Захиргаа, хуулийн тасаг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, yuotube суваг), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;<br>Авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх; | | Захиргаа, хуулийн тасаг, хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч |
| Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Шинээр томилогдсон болон эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг, ёс зүйн сургалтад хамруулсан байх; | "Татварын албаны ажилтан, албан хаагчийн 2023 оны сургалтын төлөвлөгөө"-нд тусган хэрэгжүүлсэн байх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Жилд | Ёс зүйн зөвлөл, Хүний нөөцийн мэргэжилтэн |
| | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | | Бүх тасаг |
| Авлигын эсрэг үйл ажиллагаандаа олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br>Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br>Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;<br>Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж дүгнэх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Жилдээ | Захиргаа, хуулийн тасаг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 3.2. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх; | Олон нийтийн хяналтыг хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;<br>Сургалт мэдээлэл авсан байх;<br>Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан, зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх; | | Захиргаа, хуулийн тасаг, хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч |
| Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Үйл ажиллагаандаа эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг, хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч |
| | 4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | Бодитой үр дүнг тооцсон байх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | | Бүх тасаг |
| Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх | 5.1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдаа танилцуулах; | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>Албан хаагчаас гаргасан санал, санаачлагыг хэлэлцсэн байх;<br>Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Жилд | Захиргаа, хуулийн тасаг |
| | 5.3."Татвар төлөгчийн өдрүүд"-ийн хүрээнд олон нийтэд чиглэсэн авлигын эсрэг сурталчилгааны ажлыг зохион байгуулах; | Татвар төлөгчийн өдрүүд-г зохион байгуулах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байх; | | Бүх тасаг |

*: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн хэрэгжилтийн явцыг 2023 оны 06 дугаар сарын 01, биелэлтийг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор нотлох ...имтын хамт Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.*

ОВСРУУЛСАН:
...ИРГАА, ХУУЛИЙН ТАСГИЙН ДАРГА [signature] А.ГАНЧИМЭГ